

бэрэн шинжилж эрсдэлийг бууруулах ба эрсдэлтэй ийл ажиллагааг хэрэгжүүлэх хоорондын тэнцвэржүүлэлтийг хийх боломж гдг.

*ХСИС-ийн Хууль сахиулахын удирдлагын
академийн суралцагч,
дэд хурандаа Г.Бат-Эрдэнэ*

БАЙГУУЛЛАГА ДАХЬ ХОВ, ЦУУРХАЛЫГ УДИРДАХ НЬ

*Таны талаарх хов живээс илүү муу зүйл гэвэл
тийм зүйл огт байхгүй байхыг л хэлэх байх.
Оскар Уайлд*

Хураангуй. Аливаа байгууллагад хов яриа, цуурхал их бага хэмжээгээр байдаг тухай судлаачид санал нэгтэй байдаг. Хов яриа, цуурхал нь байгууллагын хэвийн ийл ажиллагааны эсрэг чиглэгдсэн байдгаараа маш хор уршигтай юм. Иймд удирдах ажилтанд хов, цуурхал түүнийг удирдах талаар товч ойлголтыг гүйхийг зорьсон юм.

Түлхүүр үг. Хов жив, цуурхал, атаархал, удирдлага.

Хууль сахиулахын удирдлагын академиас шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагын сургалтын эрэлт, хэрэгцээг тодорхойлох судалгааны ажлыг 2016 оны 02-р сарын 24-ний өдөр явуулсан. Судалгааны дүнд Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагын удирдах ажилд тулгардаг нийтлэг бэрхшээлийг тодруулахад багагүй хувь нь “хов, цуу яриа” гэж үзсэн байна¹. Ийм орчинд ажиллахад байнга айдас, түгшүүр түрүүлж, сэтгэл зүйн дарамтад орж байдаг. Учир иймийн тул хорон санаа, атаа жтүү вэрлгчийг муу зүйлтэй зүйрлэхэд ч багадна.

Ховоор хүүцлөдгчид өөрт оногдсон өөргөө биелүүлж, ажил хэргийг урагшлуулах тухай бодохоосоо илүү бусдын аар саар өөг ажиж, өсгөж томруулан нөхдийнхөө хэлсэн өг зөвлөмж, шаардлага, шүүмжлэл, дүгнэлтийг хлээн авч хэрэгжүүлэхийн оронд зориуд нөгөө өнцгөөс нь харж, яс хаяж, хатгасан буруу мэдээлэл дамжуулж хамт олныг хутгаж, хорон санаагаа хэрэгжүүлдэг. Ховонд автсан удирдлага буруу ташаа дүгнэлт, шийдвэр гаргаж, хамтран зүтгэгчдээ бодитой дүгнэж чадахгүйд хүрч нэлэмжээ алддаг. Ажил хэргийн ноён нуруу болсон нөхдөөсөө холдож, нэр нөлөө нь буурч, хэн ч биш болдог².

Хууль сахиулахын удирдлагын академаас 2016 онд Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагын сургалтын эрэлт хэрэгцээг тодорхойлох судалгаа,

² Х.Лутчимэг, Л.Дамдинсэрэн. Удирдахуйн ухаан. УБ. 2013. 243-244 дахь тал.

Хов жив. цуурхал нь аль ч байгууллагад байдаг эзэгдэл тул түүнийг сэтгэл зүйн шинжлэх ухаан судлаж ирсэн. Жэфри Паркер гэгч Мичиганы их сургуулийн сэтгэл судлалын профессор судалгааныхаа явцад өсвөр насны эрэгтэй хүүхдүүд цагийн дотор дунджаар 18 удаа ямар зүйл ярьдаг болохыг тогтоожээ. Тэдний ярианы 50% хувийг энэ эрдэмтэн хов жив гэж тодорхойлсон байна. Харин эрэгтэй хүүхдүүд хоорондын нөхөрлөл бат бэх байх тусам хамтдаа өнгөрүүлдэг цагаа хов жив, цуу ярианд зарцуулах нь улам багасдаг байхад охидууд найз болох тусам хоорондоо хов жив ярилцах нь нэмэгддэг байна. Нас ахихын хэрээр хов живийн агуулга тун бага өөрчлөгддөг ажээ¹.

Хэдийгээр хүүхдүүс голдуу хов, цуурхал хоёрыг заагалдаггүй ч гэлээ сэтгэл судлаачдын хувьд энэ хоёр ойлголт нь өөр хоорондоо нэлээд ялгаатай зүйлс байдаг юм. Удирдлага гар, санаа нийлж эв нэгдэлтэй хамтран ажиллаж чадвал атаа жтүү өвөрлөн ховоор хүүцлэгчийг амьдрах орон зайгүй болгож нэвтрэх нөх сувийг нь хааж чаддаг. Тэр удирдлагын хоорондох өчүүхэн сиймхийг андахгүй нэгийг нь нөгөөгийн эсрэг тавьдаг. Тэгэхдээ арай шударга нэнч, ажлын төлөө сэтгэл нь өвдөж бусдад зарчимч шаардлага тавьж, онож алдан, хамт олонд нөлөөлж чаддаг удирдлагын эсрэг өөрийнхөө эрхшээлд амархан орох сул, хувийн амбицтай удирдлагыг голдуу турхирч хамт олны цөм болсон ажилтны нэр төрийг унагах, мохоох ганцаардуулах санаархлаа хэрэгжүүлэхийг зорьж, элдэв арга саам хэрэглэдэг юм. Иймээс удирдлагын баг дуулбал дуу нэг. дугтарвал хүүч нэг, нэг санаа нэгдмэл зорилготой байж. түүнийхээ төлөө хийггүй хамтран хов цуурхал яриаг хэн нь ч эс сонсож ажиллавал атаа жтүү, хов живийн хар манан усан дээр хөвх хүүс лугаа замхран хүүч нь буурч. тэдний нэн дөр төрхийг, хамт олны гишүүн бүр мэдэж, хэн ч тоохгүй болж жингийн цуваа цаашилж. ноход боргон хоцордгийн адил ямар ч нөлөөгүй болдог. Ажил багатай, зав ихтэй, хяналт шалгалт сул, хүнтэй тулж ажиллаж чаддаггүй тэр орон зай атаа жтүү, хов жив өрнөх шимтэй хүрс болж байдаг. Хүн бүрийг жигд ачаалалтай ажиллуулж, өндөр зарчимч шаардлага, шүүмжлэлтэй байдаг хамт олны дунд хов жив, атаа жтүү гардаггүй юм.²

Бас хийх ажлыг нь судла, тэнцүүл, ачаалал бага хүүхдүүс цуурдаг, хов жив ярьдаг, анхаарлаа сарниулж элдэв зүйл хүүрлөж байгаад ч осол гэмтэлд ордог тохиолдол их бий. Байгууллагадаа таарсан бүх хүн мөрдөхүйц 70-80% нь ядаж хэрэгжихүйц тийм ёсгүйн дөрэм удирдлагууд

www.biznetmork.mn

² Х.Лутчимэг, Л.Дамдинсүрэн. Удирдахуйн ухаан. УБ. 2013. 244-245 дахь

хэлэлцээд батлуулаад мөрд¹. Энэ ажилд байгууллагын гишүүн бөрийг идвэхтэй оролцуулж нэлэж дүгнэж хэвших шаардлагтай. Мөн судлаачид японы 5 С-ийн загварыг зөвлөдөг байна. Монгол хэлэнд буулгавал сайн ангилан ялгах, сайтар цэгцлэн зохион байгуулах, сайхан цэвэрлэж цэмцийлгэх, стандартчилан хэвшүүлэх, сахилга батыг төлвшүүлэх гэсэн утгатай юм. 5С хтлбөрийг хэрэгжүүлснээр хамгийн ндэр бтээмжтэй хамт олон тдийггүй хамгийн бтээмжтэй байгууллага болох анхны алхам болно гэж ойлгож болно. 5С хтлбөрөөр дамжуулан ажилчдыг идэвхжүүлж, сургаж, 5С-ийг практикт хэрэглэснээр зөвхөн ажлын байрыг сайжруулаад зогсохгүй ажилчдын ажилдаа хандах хандлагыг өөрчилж, илүү бтээлч, бтээмжтэй байгууллага бий болгох юм. Мөн байгууллагын уур амьсгал сайжраад зогсохгүй байгууллагын соёлыг төлвшүүлдэг².

Дүгнэлт.

Удирдагч хүний эрхэмлэж явах зүйл бол хов яриа, цуурхалыг дэврээлгүй дарж байх явдал юм. Гэхдээ хов яриа, цуурхал бөрийн араас мөрдөж цаг хугацаа зарцуулах нь өр дүн багатай болов уу. Харин хамт олны уур амьсгалыг өөрчлөх тэдэнд нэгдмэл зорилго зорилтыг нь ойлгуулж лгөх. Менежментийн мэдлэгээ дээшлүүлэн аливаа буруу хандлагаас урьдчилан сэргийлж ажиллах нь өр дөнтэй байх юм.

*ХСИС-ийн Хууль сахиулахын удирдлагын
академийн 811 дүгээр дамжааны сонсогч,
цагдаагийн ахмад Б.Эрдэнэхи*

III Ө ХИЙН ШИНЖИЛГЭЭНИЙ БАЙГУУЛЛАГЫН ХӨ ГЖЛИЙН ЧИГ ХАНДЛАГА

Хураангуй. Өнөөгийн шүүхийн шинжилгээний байгууллагын төлөвлөлт, удирдлага зохион байгуулалт, өйл ажиллагаанд хийх өөрчлөлт, шинэчлэлийн бодлогыг хэрэгжүүлэх, гадаадын бусад улс орны туршлагыг нэвтрүүлэн хөгжүүлэх шаардлага тулгарч байна.

Төлхөөр өгс. Шүүхийн шинжилгээний байгууллага, хөгжил, шинэчлэлт, чиг хандлага.

Монгол Улсын Засгийн газрын 2005 оны 3 дугаар сарын 23-ны өдрийн 63 дугаар тогтоолоор Хууль зүй, дотоод хэргийн сайдын эрхлэх асуудлын хүрээнд Шүүхийн шинжилгээний өндэсний төвийг (2009 оноос Шүүхийн шинжилгээний өндэсний хүрээлэн нэртэй болсон) байгуулсан.^{1 2}

¹ biznetmork.mn

² Н.Цэнд, Г.Батхэрэл, Я.Шуурав. Менежмент сурах бичиг. УБ. 2013.

Мөн 2007 оны 270 дугаар тогтоолоор аймгийн цагдаагийн газар, хэлтсийн криминалистикийн шинжээч, аймгийн нэгдсэн эмнэлгийн шинжээч эмч нарыг нэгтгэн аймгийн шүүхийн шинжилгээний алба, нийслэлийн дүүргүүд, Замын цагдаагийн газар, Төмөр замын цагдаагийн хэлтсийн криминалистикийн шинжээчдийг нэгтгэн Нийслэлийн шүүхийн шинжилгээний албыг байгуулахаар шийдвэрлэжээ. Энэхүү шийдвэрийг хэрэгжүүлэх бэлтгэл ажлыг жил гаруйн хугацаанд хангасны дүр дүнд 2009 оны 1 сарын 1-ний дүрээр аймаг, нийслэлийн шүүхийн шинжилгээний албыг Засаг даргын хэрэгжүүлэгч агентлагийн статустайгаар байгуулсан нь дэлхийн дүр хөгжилтэй орны жишигт нийцсэн ололт амжилт болсон юм.

Гадаадын дүр хөгжилтэй улс орны Шүүхийн шинжилгээний байгууллага нь улс орныхоо нийгмийн бэхий л салбарт үйл ажиллагаагаа явуулдаг. Хууль сахиулах чиг бүлэг бүхий байгууллагаас гадна төрийн болон төрийн бус байгууллага, хувийн хэвшлийн салбарт ч үйл ажиллагаа явуулах зарчмаар биеэ даасан бусад шинжлэх ухаантай салшгүй холбоотой бүлгжин хөгжиж иржээ.

АНУ нь шүүх шинжилгээний олон жилийн туршлагатай бүгд анхнаасаа холбооны улс болон бүрдсэн учраас муж бүрт алба анх өссөн байна. Мөн улмаар АНУ-ийн хэмжээнд үйл ажиллагаагаа явуулдаг байгууллага (*Нууц алба-Secret service, ХМТ-FBI, Архи, хар тамхи, галт зэвсэг, тэсрч дэлбэрэх бодистой тэмцэх алба-ATF, Эмийн бодист хяналт тавих алба-DEA*) бий болсноор холбооны улсын хэмжээний лабораториуд байгуулагдсан байна. Үүний хажуугаар олон төрлийн бизнесийг дэмждэг энэ улсад хувийн шүүх шинжилгээний лаборатори, бие даасан шинжээчид үйл ажиллагаа явуулах болсон.

2013 онд Хууль зүйн департамент болон Үндэсний стандарт, технологийн газар харилцан ойлголцох санамж бичигт гарын дсэг зурсан бүгд Үндэсний шүүх шинжилгээний комиссыг байгуулсан байна. Энэ байгууллагыг Холбооны зүвлх хорооны хуулийн дагуу Хууль зүйн департамент байгуулж Үндэсний стандарт, технологийн хүрээлэн болон Хууль зүйн департамент хамтран 2 талаас нийт 30 комиссын гишүүнийг томилсон байна. Үндэсний шүүх шинжилгээний комиссын дэргэд шүүх шинжилгээний салбарууд болох ДНК, Баримт бичиг судлал, хар тамхи, хор судлал, гал болон тэсрэх бодис, галт зэвсэг, гарын мөр гэх мэт 21 ажлын хэсэг байгуулагдан нэгдсэн стандарт, шинжилгээний арга аргачлал боловсруулахаар ажилладаг.

БНСУ-ын хамгийн том шүүх шинжилгээний хүрээлэн болох Аюулгүй байдал болон нийтийн захиргааны яамны дэргэдэх Шүүх